

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВ” ХХК-ИЙН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: САГ-2026/77/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас:260512 Цахим хаяг: Chantsaldulam.P@audit.gov.mn Аудитор: Т.Баасанцэнд Утас:261628 Цахим хаяг: Baasantsendt@audit.gov.mn Их Наяд Аудит ХХК-ын захирал: Х.Ариунзул Утас: 99077062 Цахим хаяг: ikhayadaudit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүүцэтгэл.....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага.....	18
5.2 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ҮЦК	Үнэт цаасны компани
ХОЭБ	Хөрөнгө оруулалтын эрхийн бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН
ХАДГАЛАМЖИЙН ТӨВ" ТӨХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ М.ЭНХСАЙХАН
ТАНАА

2026.03.16 № 06/645
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 748 дугаар тогтоол, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирлын А/150 тушаалаар 178 нэр төрлийн 341.5 сая төгрөгийн балансын үнэ, 133.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгө, 27 ширхэг 2.2 сая төгрөгийн бараа материалыг балансаас шилжүүлсэн байна.

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн өгөгдлийн санг, шинэчлэх, иргэдийн мэдээллийн баяжуулалтын хүрээнд 6 арга хэмжээ, үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Биржийн бус зах зээлийн арилжаа, төлбөр тооцоог блокчэйн технологид шилжүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо болон технологийн шийдлийг нэвтрүүлсэн “АНД Глобал” групптэй хамтран ажиллаж төслийг амжилттай хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Монгол улсын засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор, Монгол Улсын сангийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 193 дугаар тушаалаар “Монгол үнэт цаасны клирингийн төв” ХХК-нийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-нд нэгтгэх арга хэмжээг хэрэгжүүлж, нэгтгэх гэрээг 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн ҮЦТХТ/НГ/23 тоотой хийж, 2 тал тооцоо нийлж тулган баталгаажуулан санхүү байдлын тайлангаар эргэлтийн хөрөнгө 2,933.4 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 17-ны 748 тогтоолоор эргэлтийн бус хөрөнгө 176.7 сая төгрөг, өр төлбөр 497.1 сая төгрөг, эздийн өмчийн дүнг 2,613.1 сая төгрөг, нийт хөрөнгө, өр төлбөр ба эздийн өмчийн дүнг 3,110.1 сая төгрөгөөр балансын үлдэгдлийг балансаас балансад нэгтгэсэн.

Бусад асуудал

Компани нь тайлант онд үнэт цааны төвлөрсөн хадгаламжид 1,186 төрлийн 393,780.3 сая ширхэг үнэт цаасыг хадгалж, биржийн бус зах зээлд арилжаалах 868 төрлийн 21,504.5 сая ширхэг төгрөгийн өрийн хэрэгсэл бүртгэн үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр хадгалж байгаа үнэт цаас, өрийн хэрэгсэл нь тайлан тэнцлийн гадуур бүртгэж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	189,008,395,876.48	222,352,763,165.05
1.1.2	Дансны авлага	181,702,622.75	438,237,624.43
1.1.4	Бусад авлага	1,098,432,254.79	1,096,794,281.32
1.1.6	Бараа материал	19,854,465.00	19,969,490.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	342,194,299.91	79,817,830.68
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	190,650,579,518.93	223,987,582,391.48
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,739,661,830.05	1,838,487,895.07
1.2.2	Биет бус хөрөнгө	118,333,981.45	1,185,186,512.31
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	108,294,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,857,995,811.50	3,131,968,407.38
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	192,508,575,330.43	227,119,550,798.86
2.1.1.1	Дансны өглөг	29,047,306.00	9,445,963.09
2.1.1.2	Ажилтан албан хаагчдад өгөх өглөг	397,996.43	1,198,956.93
2.1.1.3	Татварын өр	19,317,149.47	25,729,855.11
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	1,307,325.99
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	46,549,441.31	50,128,527.07
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	174,658,719,793.41	202,192,162,052.03
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	174,754,031,686.62	202,279,972,680.22
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	714,385,161.20	1,185,182,504.42
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	714,385,161.20	1,185,182,504.42
2.2	Өр төлбөрийн нийт дүн	175,468,416,847.82	203,465,155,184.64
2.3.1	Өмч - төрийн	5,000,000,000.00	7,000,000,020.75
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	132,924,938.00	82,881,103.13
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	26,624,000.00	1,182,682,466.76
2.3.9	Хуримтлагдсан ашиг	11,880,609,544.61	15,388,832,023.58
2.3.11	Эздийн өмчийн дүн	17,040,158,482.61	23,654,395,614.22
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	192,508,575,330.43	227,119,550,798.86

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,606,603,432.90	4,082,191,355.95
2	Борлуулалтын өртөг	827,466,197.90	1,230,183,252.71
3	Нийт ашиг (алдагдал)	2,779,137,235.00	2,852,008,103.24
4	Хүүний орлого	3,921,933,126.65	4,793,673,434.36
5	Бусад орлого	-	17,549,363.12
6	Ерөнхий ба удирдлагын зардал	1,870,197,896.10	2,288,515,247.59
7	Бусад зардал	418,106,475.00	15,272,151.47
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(21,305.50)	43,524.03
9	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,412,744,685.05	5,359,487,025.69

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

10	Орлогын татварын зардал	501,974,443.38	537,239,491.76
11	Татварын дараах ашиг (алдагдал)	3,910,770,241.67	4,822,247,533.93
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,910,770,241.67	4,822,247,533.93

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	5,000,000,000.00	132,924,938.00	26,624,000.00	10,034,119,762.59	15,193,668,700.59
Залруулсан үлдэгдэл	5,000,000,000.00	132,924,938.00	26,624,000.00	10,034,119,762.59	15,193,668,700.59
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				3,910,770,241.67	3,910,770,241.67
Зарласан ногдол ашиг				2,064,280,459.55	2,064,280,459.55
2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	5,000,000,000.00	132,924,938.00	26,624,000.00	11,880,609,544.71	17,040,158,482.71
Залруулсан үлдэгдэл	5,000,000,000.00	132,924,938.00	26,624,000.00	11,880,609,544.71	17,040,158,482.71
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				4,822,247,533.93	4,822,247,533.93
Өмчид гарсан өөрчлөлт	2,000,000,020.75		1,156,058,466.76		3,156,058,487.51
Зарласан ногдол ашиг				1,314,025,054.96	1,314,025,054.96
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		50,043,834.87			
2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	7,000,000,020.75	82,881,103.13	1,182,682,466.76	15,388,832,023.68	23,654,395,614.32

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	18,498,136,066,508.90	7,423,477,914,601.05
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	10,673,069,134.63
1.1.3	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	3,921,933,126.65	61,923,741.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	18,494,214,133,382.30	7,412,742,921,725.42
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	18,402,462,598,475.00	7,391,586,157,762.54
1.2.1	Ажиллагсаддаа төлсөн	1,620,550,454.00	1,604,968,112.22
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	367,352,353.92	173,142,343.99
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	28,973,023.00	44,517,957.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	30,382,754.00	121,313,373.14
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,332,300.00	1,795,425.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	647,481,890.29	484,486,874.47
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,973,213.20	260,548,329.29
1.2.9	Бусад мөнгөн зарлага	18,399,762,552,486.60	7,388,895,385,347.43
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	95,673,468,033.94	31,891,756,838.51
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,921,933,126.65	3,618,529,395.57
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	3,921,933,126.65	3,618,529,395.57
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	646,271,137.46	210,533,824.67
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	597,266,137.46	191,640,602.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	49,005,000.00	-
2.2.3	Бусад	-	18,893,222.67
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,275,661,989.19	3,407,995,570.90
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,876,618,600.00	1,955,385,120.84
3.2.4	Төлсөн ногдол ашиг	1,876,618,600.00	1,955,385,120.84
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,876,618,600.00)	(1,955,385,120.84)
3.4	Валютын ханшийн зөрүү	(21,305.57)	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	97,072,490,117.56	33,344,367,288.57
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	91,935,905,758.92	189,008,395,876.48
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	189,008,395,876.48	222,352,763,165.05

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2025 гүйцэт/ 2024 гүйцэт	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:									
1	Үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээний орлого	м.төг	2,019,373.1	1,951,285.7	1,547,390.3	(471,982.9)	-23%	403,895.4	79%
	Үнэт цаасны өмчлөх эрх бүртгэлийн орлого	м.төг	1,303,813.3	1,452,547.2	2,408,963.7	1,105,150.4	85%	(956,416.5)	166%
	Кастодианы үйлчилгээний орлого	м.төг	26,946.0	30,079.0	42,442.4	15,496.4	58%	(12,363.4)	141%
	Төлбөр гүйцэтгэх үйлчилгээний орлого	м.төг	197,183.0	419,240.2	83,395.0	(113,788.1)	-58%	335,845.3	20%
	Бусад орлого	м.төг	59,266.6	50,000.0	17,549.4	(41,717.3)	-70%	32,450.6	35%
	Үйл ажиллагааны бус орлого	м.төг	3,921,933.1	3,390,466.0	4,793,673.4	871,740.3	22%	(1,403,207.4)	141%
2	Нийт орлого	м.төг	7,528,515.2	7,293,618.1	8,893,414.2	1,364,898.8	18%	(1,599,796.0)	122%
3	Нийт зардал	м.төг	3,115,770.6	3,823,242.6	3,533,970.4	418,199.8	13%	289,272.2	92%
3	Үүнээс: Ерөнхий ба удирдлагын зардал	м.төг	1,870,197.9	2,300,000.0	2,288,515.0	418,317.1	22%	11,485.0	100%
	4	Татварын өмнөх ашиг	м.төг	4,412,744.6	3,470,375.6	5,359,487.0	946,742.3	21%	(1,889,111.4)
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	3,910,770.2	3,123,338.1	4,821,976.8	891,889.30	23%	(1,698,638.70)	154%
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	684,191.2	791,041.6	977,129.9	292,938.7	43%	(186,088.4)	124%
	а/ Орлогын татварт	м.төг	482,657.2	347,037.6	537,467.0	54,809.8	11%	(190,429.4)	155%
	б/ НӨТ	м.төг	10,823.0	2,000.0	1,087.3	(9,735.7)	-90%	912.7	54%
	в/ НДШ	м.төг	36,709.6	249,404.0	248,541.7	211,832.1	577%	862.3	100%
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	138,288.6	174,000.0	173,323.7	35,035.1	25%	676.3	100%
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	15,300.0	15,300.0	15,300.0	-	0%	-	100%
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	99.2	900.0	354.2	255.0	257%	545.8	39%
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	313.6	2,400.0	1,056.0	742.4	237%	1,344.0	44%
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	1,876,618.6	1,955,385.1	1,955,385.1	78,766.5	4%	-	100%
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	38.0	40.0	38.0	-	0%	2.0	95%
9	Нийт цалингийн сан	м.төг	1,586,136.9	1,995,232.0	1,990,216.4	404,079.5	25%	5,015.6	100%
10	Нэг ажилтаны сарын дундаж цалин	м.төг	2,296.3	2,824.5	3,086.1	789.8	34%	(261.6)	109%

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.4	0.5	0.4	(0.0)	-4%	0.1	76%
12	Хөрөнгө оруулалт	м.төг	1,248,221.2	2,787,250.0	247,414.2	(1,000,807.0)	-80%	2,539,835.9	9%
13	Нийт авлага	м.төг	181,702.6	159,107.0	157,937.0	(23,765.6)	-13%	1,170.0	99%
	Үүнээс: Найдваргүй	м.төг	65,160.0	40,160.0	40,160.0	(25,000.0)	-38%	-	100%
14	Нийт өглөг	м.төг	809,697.1	959,923.7	1,263,217.0	453,520.0	56%	(303,293.3)	132%
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	95,311.9	50,000.0	78,035.0	(17,276.9)	-18%	(28,035.0)	156%
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	714,385.2	909,923.7	1,185,182.0	470,796.8	66%	(275,258.3)	130%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК нь Үнэт цаасны тухай хуульд заасны дагуу үнэт цаас гаргагч болон бусад оролцогч байгууллагуудтай байгуулсан гэрээний үндсэн дээр үнэт цаасыг хадгалах, түүнтэй холбоотой бүртгэл хөтлөх үйл ажиллагааг эрхлэх, биржийн болон биржийн бус арилжааны өмчлөх эрхийг баталгаажуулан бүртгэх, кастодианы үйлчилгээг хавсран эрхлэх чиг үүрэгтэй Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Компани нь эрхэм зорилгоо “Үнэт цаасны хадгаламж, өмчлөх эрх бүртгэлийн аюулгүй найдвартай байдлыг ханган, клиринг, төлбөр тооцоог олон улсын стандарт жишигт нийцсэн үйлчилгээг үзүүлнэ.” гэж тодорхойлсон бөгөөд эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хадгаламжийн нэгдсэн мэдээллийн сангийн цогц үйлчилгээг өргөжүүлэх
- Үнэт цаасны бүртгэлийн найдвартай хадгалалтыг хангах
- Бизнесийн орчин болон дотоод, гадаадын хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн өөрчлөлтөд нягт оролцож, хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагч болон үнэт цаасны байнгын өөрчлөлт шинэчлэлт хийх

Мөн “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК нэгдэж буйтай холбоотойгоор Клирингийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авч үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК нь Монголын хөрөнгийн бирж 1991 онд үүсгэн байгуулагдсан цагаас биржийн бүрэлдэхүүнд “Төлбөр тооцоо хадгаламжийн алба” нэртэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Монгол улсын үнэт цаасны зах зээлийн тухай хууль 1994 онд анх батлагдаж, улмаар 2002 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчлэн баталснаар хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц тодорхойлогдсон байна. Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 72 тоот тогтоолоор “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК бие даасан байгууллага болон өргөжиж, үнэт цаасны бүртгэл, хадгаламж болон төлбөр тооцооны үйлчилгээг эрхлэн гүйцэтгэж байв.

Компаний үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар тус төв нь Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Компанийн өмчлөгч нь төр байх бөгөөд түүнийг төлөөлөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Сангийн яам хэрэгжүүлнэ”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Хувьцаа эзэмшигчийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна” гэж заасны дагуу үйл ажиллагаа явуулж байна.

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК нь Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Төрийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Хөдөлмөрийн тухай, Татварын багц хуулиуд, Санхүүгийн зохилцуулах хорооны болон тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батлагдсан Үнэт цаасны төлбөр тооцоог Т-2 горимоор гүйцэтгэх, Төлбөрийн үйлчилгээний журам, Үнэт цаасны хадгаламжийн журам, Мөнгөн хөрөнгийн гүйлгээний журам болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байна.

Компаний удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэллээ.

Тайлант онд дотоод хяналтын алба нь үнэт цаасны өмчлөх эрх бүртгэл, үнэт цаасны бүртгэл гэсэн санхүүгийн үйл ажиллагааны 2 чиглэлд 6 удаагийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, үр дүнг гүйцэтгэх захиралд танилцуулж, биелэлтийг хангуулж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ТУЗ-ын 2025 оны 15 тоот тогтоолоор баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,611.0 сая төгрөгөөр буюу 18.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	189,008,395.9	222,352,763.2	33,344,367.3
Авллага	1,280,134.9	1,535,031.9	254,897.0
Бараа материал	19,854.4	19,969.5	115.1

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Урьдчилж төлсөн зардал/тооцоо	342,194.3	79,817.8	(262,376.5)
Үндсэн хөрөнгө	1,857,995.8	3,131,968.4	1,273,972.6
Нийт хөрөнгө	192,508,575.3	227,119,550.8	34,610,975.5
Өр төлбөр	175,468,416.8	203,465,155.2	27,996,738.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	17,040,158.5	23,654,395.6	6,614,237.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	192,508,575.3	227,119,550.8	34,610,975.5

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 33,344.3 сая төгрөгөөр өссөн нь Монгол улсын засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 61 тоот тогтоолоор “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д нэгтгэх шийдвэр гарсны дагуу 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн тайлангаар 2,806.2 сая төгрөгийн харилцахын үлдэгдэл нэгтгэсэн, мөн Эрдэнэс таван толгойн ХК-ийн 2 удаагийн ногдол ашиг зарлахад нэр данс зөрүү болон бусад шалтгаанаар тараагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгөтэй холбоотой байна.

Дансны авлагын үлдэгдэл 254.9 сая төгрөгөөр өссөн нь “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д нэгтгэх шийдвэр гарсны дагуу 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн тайлангаар 125.0 сая төгрөгийн авлага нэгтгэсэн, 2025 оны 11,12 дугаар саруудад санхүүгийн хөрөнгөд бүртгэлтэй хугацаатай хадгаламжийн хугацаанууд дуусаж суутган тооцсон орлогын албан татвараар өссөн байна.

Урьдчилж төлсөн зардал/тооцооны үлдэгдэл 262.4 сая төгрөгөөр буурсан нь тус дансанд бүртгэсэн мэдээллийн аюулгүй байдлын лиценз, сертификатын хүчинтэй байх хугацааг биет бус хөрөнгө руу шилжүүлэн бүртгэснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,273.9 сая төгрөгөөр өссөн нь 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 61 тоот тогтоолоор “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д нэгтгэх шийдвэр гарсны дагуу 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн тайланг нэгтгэсэнтэй холбоотой 176.7 сая төгрөгийн балансын үнэтэй хөрөнгө, ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 02-ны А-1/2319 тоот албан тоотоор Гаалийн ерөнхий газраас 96.7 сая төгрөгийн балансын үнэтэй Ниссан патрол Y-62 маркийн, 62-50 улсын дугаар JN8BY2NY6L9308385 арлын дугаартай тээврийн хэрэгслийг балансас баланс шилжүүлж авсан мөн худалдан авалтын төлөвлөгөөний дагуу 195.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан. ТӨБЗГ-ын 2025 оны А-2/2435 албан тоотоор 66 нэрийн 113.7 сая төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан. Дуусаагүй барилга дансанд бүртгэсэн 108,294.0 сая төгрөг нь компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан хөрөнгийн зах зээл тэлэлт болон үндсэн үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ өргөжсөнтэй холбоотойгоор шинэ байрны шаардлага үүссэн. Барилгын хөгжлийн төв болон холбогдох төрийн мэргэжлийн байгууллагын магадлалаар баталгаажсан оффисын барилгын ажлын зураг, үүнтэй холбоотой техникийн нөхцөлүүдийг авах шаардлага үүссэн бөгөөд холбогдон гарсан зардлуудыг НБББББ-ийн дагуу хуримтлуулан бүртгэсэн байна.

Дансны өр төлбөрийн үлдэгдэл 27,993.7 сая төгрөгөөр өссөн нь “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д нэгтгэх шийдвэр гарсны дагуу 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн тайланг нэгтгэсэнтэй холбоотой 25.7 сая төгрөгийн өр төлбөр, 470,797.3 сая төгрөгийн нөөц өр төлбөр балансас баланс шилжиж ирсэн, мөн харилцагчдад төлөх 143,929.8 сая төгрөгийн ногдол ашгийн өглөгтэй холбоотой байна.

Эздийн өмчийн үлдэгдэл 6,614.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д нэгтгэх шийдврийн дагуу 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн тайлангаар 2,613.0 сая төгрөгийн өмч нэгтгэсэн, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны А-2/2435 дугаарт албан тоотын дагуу дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгийг акталж даснаас хассантай холбоотой 50.0 сая төгрөгөөр буурсан, бусад хөрөнгөд компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан хөрөнгийн зах зээл тэлэлт болон үндсэн үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ өргөжсөнтэй холбоотойгоор шинэ байрны шаардлага үүссэн холбоотой Нийслэлийн засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/1218 тоот захирамжаар олгогдсон Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо 1461503533 нэгж талбарын дугаарт 1,100 м.кв газрыг Хөрөнгө үнэлгээний “Хөрөнгө эстимэйт үнэлгээ” ХХК-аар үнэлгээ хийлгэж 1,156.0 сая төгрөгөөр бүртгэсэн, тайлант үеийн үр дүн зэргээс голлон нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тушаалаар 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр нийт орлого 7,293.6 сая төгрөг, нийт зардал 3,813.2 сая төгрөг, худалдан авалтыг 297.2 сая төгрөгөөр хүргүүлж, Монгол Улсын сангийн сайдын 2025 оны 73 дугаар тушаалаар баталсаныг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 13 дугаар тогтоолоор нийт зардлыг 10.0 сая төгрөг, худалдан авалтыг 2,490.0 сая төгрөгөөр нэмж тодотгол хийсэн байна.

Тайлант оны нийт орлогыг 7,293.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 3,823.2 сая төгрөгөөр, 3,123.3 сая төгрөгийн ашигтай ажиллагаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2,787.3 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 8,893.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,534.0 сая төгрөгийн зардал гарган, 5,359.5 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 8,893.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,599.8 сая төгрөг буюу 17.9 хувиар давсан нь үндсэн үйл ажиллагааны орлого 196.6 сая төгрөг буюу 105 хувиар, үйл ажиллагааны бус орлого 1,403.2 сая төгрөг буюу 141 хувиар давж биелсэн нь нийт орлогын төлөвлөгөөг 22 хувиар давуулан биелэхэд голлон нөлөөлжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 3,534.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 289.2 сая төгрөг буюу 8.2 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь 2025 оны 05 дугаар албан даалгавартай холбоотойгоор тэвчиж болох зардлын санхүүжилтийг зогсоосон нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 12 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 247.4 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Нээлттэй тендер шалгаруулалтын 2,480.0 сая төгрөгийн системийн худалдан авалтын тендерээр компани шалгараагүй тул 9%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж 19.8 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна.

Тайлант онд цэвэр ашиг 5,359.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,889.1 сая төгрөгөөр илүү байгаа нь орлогыг 22 хувиар давуулан биелүүлсэнээс нөлөөлжээ.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 88 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухайн санхүүгийн жилийн Улсын төсөв болон Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай" тогтоолоор жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан цэвэр ашгийн 50 хувь болон төрийн эзэмшилд хамаарах эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр ногдол ашгийг жил бүр улсын төсөвт төвлөрүүлдэг. 2025 онд 2024 оны цэвэр ашгийн 50 хувь буюу 1,955.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар орлого, зардал, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Их Наяд Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Энхтуул, аудитор М.Мөнхзул нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Х.Ариунзул, Санхүүгийн аудитын газрын аудитор Т.Баасанцэнд, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дүгээр сарын 04-ний өдрийн 01/127 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 3,115.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 31.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд орон тоог давхардуулан тогтоохгүй байх, тэтгэмж, урамшуулал олгохгүй байх, бэлэг дурсгалын зүйл, согтууруулах ундаа худалдан авахгүй байх, албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, албан томилолтоор онгоцоор явахад энгийн ангиллаар зорчих, ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авалтыг гүйцэтгэх зэргээр хуульд заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой төлөвлөсөн горим сорилыг гүйцэтгэхэд тус хуулийг зөрчсөн асуудал аудитын явцад илрээгүй болно.

1. Компаний орон тооны цомхотголын талаар

Тус компани нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 05 дүгээр сарын 10-ны өдрийн 07 дугаар хурлын тогтоолоор бүтэц орон тоог 40 ажилтнаар баталсан ба Засгийн газрын чиглэлийн дагуу 9 хувиар бууруулах тогтоолын дагуу нөхөн томилгоо хийгдээгүй 38 ажилтан ажилласан байна.

2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

Тус компани нь Сангийн сайдын 2025 оны 73 дугаар тушаал, гүйцэтгэх захирлын 2025 оны А/30 тушаалыг үндэслэн нэг өдрийн унаа 5,000.00 төгрөг, хоолны хөнгөлөлтийг 15,000.00

төгрөгөөр баталсан. Тайлант онд төсөв 197.6 сая төгрөгөөр батлагдсан, гүйцэтгэлээр 177.6 сая төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлтийг зарцуулсан байна.

3. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүн:

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардалд 21.2 сая төгрөгийг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 12.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

4. Гадаад томилолтын судалгааны үр дүн:

Гадаад томилолтын зардалд төлөвлөгөөгөөр 94.2 сая төгрөг төсөвлөсөн ба Япон, Бельгийн хаант улс руу Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан "Дэлхийн Монголчуудын анхдугаар их наадам"-д ЭТТ 1072 хувьцааны мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээнд 50.4 сая төгрөг, БНСУ руу Солонгос улсын төвлөрсөн хадгаламжийн байгууллага /KSD/-тай систем шинэчлэлтэй холбоотой зөвлөгөө, мэдээлэл, туршлага судлах арга хэмжээний зардалд 21.4 сая төгрөг, гүйцэтгэлээр нийт 71.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

5. Хэвлэл мэдээллийн судалгааны үр дүн:

Хэвлэл мэдээлэллээр “ЭТТ” ХК нь 2019, 2022, 2023, 2024-1, 2, 3 ногдол ашиг авсан эсэх дэлгэрэнгүй мэдээллийг E-Mongolia-аар шалгах зааврыг видео хэлбэрээр дамжуулж, Chig.mn, Graphnetwork, Mgl times зэрэг сангийн хамтран ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан компанийн үйл ажиллагаатай холбоотой шинэлэг контентуудыг нийтэд цацаж, машинтай өдөрлөгт Монголын хөрөнгийн биржийн MSE HALL-д “Хөрөнгө оруулагчдын өдөр” нээлттэй өдөрлөгт оролцож иргэдэд үнэт цаасны дансны дэлгэрэнгүй мэдээлэл, “ЭТТ 1072”, ХОЭБ холбоотой мэдээллийг өгч, Zangia.mn ашиглан 2024 онд нийт 6 удаа ажлын байрны зар оруулснаас 77 анкет хүлээн авч 4 хүнийг ажлын байранд шалгаруулах зардалд 10.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

6. Программ хангамжийн судалгааны үр дүн:

Тус компани нь үйл ажиллагаандаа 18 нэр төрлийн 220.6 сая төгрөгийн өртөг бүхий программуудыг ашигладаг ба жилийн хураамжийн дүнд 7.2 сая төгрөг төлсөн байна.

Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангаар шалгасан нийцлийн асуудлаар илэрсэн нийт 231.5 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус компани шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих худалдан авах ажиллагааны 12 дугаар сарын 231.5 сая төгрөгийн 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмыг уншиж судлан хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэл байршуулах ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч компаний 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, зардал, орлогын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитаар 1,253.0 сая төгрөгийн илрүүлэлтийг шалгагдагч компанид танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар илэрсэн 4 алдаа, 2 зөрчил илэрсэнд 1,252.4 сая төгрөгийн 4 алдааг залруулж, жилийн эцсийн аудитад 1 зөвлөмж, 1 актыг нэгтгэсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 8.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 26.9 сая төгрөгийн 2 зөвлөмж өгснийг нотлох баримттай тулган шалгахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	8,966.5	3	8,966.5	100.0
Зөвлөмж	2	26,895.1	2	26,895.1	100.0
Нийт дүн	5	35,951.6	5	35,951.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өмнөх онд удирдлагын буруутай үйл ажиллагаатай холбогдон үүссэн 34.9 сая төгрөгийн авлагын нэхэмжлэх Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх дээр хянан шийдвэрлэгдэх асуудлыг тайлант онд шийдвэрлээгүй, хэрэгжих шатанд байгаа тул дараагийн аудитаар анхааран үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,337.8¹ сая төгрөгийн 7 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа: Үүнд,

- Мөнгөн хөрөнгийн зарлагыг бүртгэхдээ хувь хүмүүст өгөх 49.6 сая төгрөгийн өглөгийг, байгууллагад төлөх өглөгийн дансаар андуурч бүртгэсэн;
- Бусад үндсэн хөрөнгөнд бүртгэх 1.9 сая төгрөгийн урлагийн бүтээлийн хөрөнгийг тавилга эд хогшилд бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй урлагийн бүтээлд 1.9 сая төгрөгийн элэгдэл зардал тооцсон;
- Харилцагчийн нэр зөрүүтэй бүртгэгдсэнээс 1,198.9 сая төгрөгийн өглөг хасах үлдэгдэлтэй тайлагнасан;
- Тайлант онд 4 төрлийн орлогыг ибаримтад 47.2 сая төгрөгөөр илүү бүртгэсэн;
- Өмнөх онд “Төгс жигүүр” ХХК-иар дээврийн засвар хийлгэж барилгыг 4.1 сая төгрөгөөр капиталжуулж бүртгэхийг 7.1 сая төгрөгөөр бүртгэсэнийг залруулахдаа орлого дансанд буруу бүртгэсэн;
- Мөнгөн гүйлгээний тайланд зардлын эдийн засгийн ангиллыг буруу сонгож 35.1 сая төгрөгийн зардлыг орлого талд хасах дүнгээр илэрхийлсэн зэрэг ажил гүйлгээг залруулсан.

Дээрх алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-д “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно” 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасантай тус тус нийцээгүй, “үнэлгээ ба хувиарлалт”, “үнэн ба зөв”, “толилуулга ба тодруулга” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 18.2 сая төгрөгийн 5 зөрчил² илэрсэнд 0.9 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 11.5 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 5.9 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 18.2 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 13.0 сая төгрөгөөр бага тул **“Өөрчлөлтгүй”** дүгнэлт өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Нэр бүхий хавсралтад дурдсан 6 албан тушаалтанд дотоод болон орон нутагт албан томилолтоор ажилласан хугацааны нөхөх төлбөртэй давхардуулан 0.5 сая төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журмын 2.2-т Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ: “2.2.1-д унааны зардал, 2.2.2-т байрны зардал, 2.2.3-т хоолны зардал” гэж тус тус заасантай нийцээгүй, “үнэн ба зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчид унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосоныг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, улсын төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт: Нэр бүхий хавсралтад дурдсан 7 ахмадуудад “ахмадуудын баяр, сар шинийн баярыг тохиолдуулан 0.2 сая төгрөгийн урамшуулал олгоно гэж дотоод журмын 8.1.5-д заасан заалтыг зөрчиж”, 0.3 сая төгрөгөөр олгож, нийт 0.3 сая төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт;”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Компанийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.1.5-д “Компанийн ажилтан 50,60,65 нас хүрсэн тохиолдолд компаниас хүндэтгэл үзүүлж, үнэ бүхий зүйл дурсгах, байгууллагаас гавьяаны амралтаа авсан ахмадуудад ахмадын өдөр, сар шинийн баярыг тохиолдуулан 200 000 /хоёр зуун мянга/ төгрөгийн мөнгөн урамшил олгоно.” гэж заасантай тус тус нийцэхгүй, “үнэн ба зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ахмадуудад илүү олгосон урамшууллыг буруутай албан тушаалтнаар төлүүлж, улсын төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Тус компаний үндсэн ажилтан жолооч, аж ахуйн ажилтан Д.Бат-Эрдэнэ нь 2018 оноос ажиллаж байгаа ба нийт 11.5 сая төгрөгийн цалин авсан байна. Гэвч тус жолооч нь тайлант онд Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөлд давхар ажиллаж сар бүр 3.0 сая төгрөг буюу нийт 36.0 сая төгрөгийн цалинтай мөн Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөл нь нийгмийн даатгалд гэрээт ажилтаны 40 кодоор бүртгэх байсныг буруу бүртгэж 01 кодоор бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйл 84.1-д “Долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй байна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тус компаний үндсэн ажилтан бусад байгууллагад давхар ажил эрхэлсэнийг ажил олгогч нийгмийн даатгалд 01 кодоор тайлагнасан зөрчлийг таслан зогсоож, 40 кодоор тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үүрэн телефоны байгууллагуудын тусгай дугаарт утасны орлогын 4.9 сая төгрөгийн и-баримтыг цахим системд зөрүүтэй үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-д “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа *татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил үйлчилгээний төлбөр тооцоог хийхдээ хууль тогтоомжид заасан анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ээлжийн амралтын мөнгийг 0.9 сая төгрөгөөр илүү тооцож олгосон ба суутган авсан цалинг цалингийн өглөг дансаар дамжуулж бүртгээгүй бусад орлого дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дансны өглөг, авлага, төлбөрийн тооцоог харилцагч бүрээр журналд тусгаж үлдэгдэлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Мөнгөн хөрөнгийн зарлагыг бүртгэхдээ хувь хүмүүст өгөх өглөгийг, байгууллагад төлөх өглөгийн дансаар андуурч бүртгэсэн байна.	1	49,647.1			1	49,647.1	1	49,647.1				
2	Бусад үндсэн хөрөнгөнд бүртгэх урлагийн бүтээлийн хөрөнгийг тавилга эд хогшилд бүртгэсэн байна.	1	1,941.7			1	1,941.7	1	1,941.7				
3	Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй урлагийн бүтээлд элэгдэл тооцож, үлдэх өртөггүй болсон байна.	1	1,912.5			1	1,912.5	1	1,912.5				
4	Харилцагчийн нэр зөрүүтэй бүртгэгдсэнээс өглөг хасах үлдэгдэлтэй илэрхийлэгдсэн байна.	1	1,198,905.4			1	1,198,905.4	1	1,198,905.4				
5	4 төрлийн орлогыг ибаримтад илүү бүртгэсэн байна.	1	47,240.7			1	47,240.7	1	47,240.7				
6	Өмнөх онд "Төгс жигүүр" ХХК-наар дээврийн засвар хийлгэж барилгыг 4,063.6 мянган төгрөгөөр капиталжуулж бүртгэхийг 7,147.3 мянган төгрөгөөр бүртгэсэнийг залруулахдаа орлого дансанд буруу бүртгэсэн.	1	3,083.7			1	3,083.7	1	3,083.7				
7	Мөнгөн гүйлгээний тайланд зардлын эдийн засгийн	1	35,068.6			1	35,068.6	1	35,068.6				

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

ангиллыг буруу сонгож орлого талд хасах дүнгээр илэрхийлсэн байна.													
Дүн	7	1,337,799.7			7	1,337,799.7	7	1,337,799.7					

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ахмадуудад ахмадын өдөр, сар шинийн баярыг тохиолдуулан 200.0 мянган төгрөгийн урамшуулал олгоно гэж дотоод журмын 8.1.5-д заасан заалтыг зөрчиж 7 ахмадад нийт 350.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	350.0	1	350.0								
2	Томилолтоор явсан 6 ажилчдад 508.5 мянган төгрөгийн хоол унааны мөнгө давхардуулан олгосон байна.	1	508.5	1	508.5								
3	Ээлжийн амралтын мөнгийг илүү тооцож олгосон ба суутган авсан цалинг цалингийн өглөг дансаар дамжуулж бүртгээгүй бусад орлого дансанд буруу бүртгэсэн байна.	1	957.7					1	957.7				
4	Үүрэн телефоны байгууллагуудын тусгай	1	4,911.7					1	4,911.7				

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	дугаарт утасны орлогын ибаримтыг цахим системд зөрүүтэй үүсгэсэн байна.												
5	Тус байгууллагын үндсэн ажилтан жолооч, аж ахуйн ажилтан Д.Бат-Эрдэнэ нь 2018 оноос ажиллаж байгаа ба нийт 11.5 сая төгрөгийн цалин авсан байна. Гэвч тус жолооч нь тайлант онд Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөлд давхар ажиллаж сар бүр 3.0 сая төгрөг буюу нийт 36.0 сая төгрөгийн үндсэн цалинтай байна. Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөлд татвар төлөгчийн ангилал гэрээт ажилтанаар бүртгэх байсныг буруу бүртгэж 01 кодоор бүртгэсэн байна.	1	11,491.6			1	11,491.6						
	Дүн	5	18,219.5	2	858.5	1	11,491.6	2	5,869.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 12 сард байршуулах худалдан авах ажиллагааны тайланг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	231,469.0					1	231,469.0
Нийт дүн	1	231,469.0					1	231,469.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 123/АД150061

Улаанбаатар хот

САГ-2026/77/А-СТА-ТӨЧГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Нэр бүхий хавсралтад дурдсан 6 албан тушаалтанд дотоод болон орон нутагт албан томилолтоор ажилласан хугацааны нөхөх төлбөртэй давхардуулан 508,460.00 /таван зуун найман мянга дөрвөн зуун жаран/ төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгосон байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журмын 2.2-т Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ: "2.2.1-д унааны зардал, 2.2.2-т байрны зардал, 2.2.3-т хоолны зардал" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон 508,460.00 /таван зуун найман мянга дөрвөн зуун жаран/ төгрөгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбазаяа, тооцооны нягтлан Б.Нарантунгалагаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн Гүйцэтгэх захирал (М.Энхсайхан)-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Х.АРИУНЗУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар

124/20150061

Улаанбаатар хот

САГ-2026/77/НА-СТА-ТӨЧГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Нэр бүхий хавсралтад дурдсан 7 ахмадуудад "ахмадуудын баяр, сар шинийн баярыг тохиолдуулан 200,000.00 /хоёр зуун мянган/ төгрөгийн урамшуулал олгоно гэж дотоод журмын 8.1.5-д заасан заалтыг зөрчиж", 250 000.00 /хоёр зуун тавин мянган/ төгрөгөөр олгож нийт 350,000.00 /гурван зуун тавин мянган/ төгрөгийг илүү олгосон байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт;", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Компанийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.1.5-д "Компанийн ажилтан 50,60,65 нас хүрсэн тохиолдолд компаниас хүндэтгэл үзүүлж, үнэ бүхий зүйл дурсгах, байгууллагаас гавьяаны амралтаа авсан ахмадуудад ахмадын өдөр, сар шинийн баярыг тохиолдуулан 200 000 /хоёр зуун мянга/ төгрөгийн мөнгөн урамшил олгоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж тус тус заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ахмадуудын баяр, сар шинийн баярын урамшууллыг хэтрүүлэн олгосон 350,000.00/ гурван зуун тавин мянган/ төгрөгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн захирал М.Энхсайхан, ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бямбазаяагаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн Гүйцэтгэх захирал (М.Энхсайхан)-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Х.АРИУНЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\AKH\2026\0316 SAG-6.Docx

1526200124



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 561/АДК0061

Улаанбаатар хот

СМН-2026/77/МА-СТА-ТӨЧГ

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын үндсэн ажилтан жолооч, аж ахуйн ажилтан Д.Бат-Эрдэнэ нь 2018 оноос ажиллаж байгаа ба нийт 11,491,587.00 /арван нэгэн сая дөрвөн зуун ерэн нэгэн мянга таван зуун наян долоон/ төгрөгийн цалин авсан байна. Гэвч тус жолооч нь тайлант онд Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөлд давхар ажиллаж сар бүр 3,000,000.00 /гурван сая/ төгрөг буюу нийт 36,000,000.00 /гучин зургаан сая/ төгрөгийн үндсэн цалинтай байна. Хөгжлийн хөтөч дэд бүтэц төсөл нь нийгмийн даатгалд гэрээт ажилтны 40 кодоор бүртгэх байсныг буруу бүртгэж 01 кодоор бүртгэсэн байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Тус байгууллагын үндсэн ажилтан бусад байгууллагад давхар ажил эрхэлснийг ажил олгогч нийгмийн даатгалд 01 кодоор тайлагнасан зөрчлийг таслан зогсоож, 40 кодоор тайлагнаж байх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн Гүйцэтгэх захирал (М.Энхсайхан), ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Бямбазаяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Х.АРИУНЗУЛ